

БНХАУ-ЫН ГАДААДАД НЭЭЛТТЭЙ БАЙХ БОДЛОГЫН ЗАРИМ АСУУДАЛ

Л. Бэгзжав

1978 оны XII сард хуралдсан ХКН-ын Төв Хорооны III бүгд хурал БНХАУ-ын түүхэнд эргэлтийн үе болж орсон. Бүгд хурлаас нам, төрийн бүх ажлын голыг эдийн засагт шилжүүлэх, энэ зууны сүүлч гэхэд улс орноо шинэчлэх том зорилт дэвшүүлсэн билээ. Энэ зорилтоо хэрэгжүүлэхийн тулд дотооддоо эдийн засгийн шинэтгэл хийх, гадаадад нээлттэй байх бодлого явууллаа. Эдийн засгийн шинэтгэл явуулахын тулд гадаад ертөнцтэй харилцаагаа өргөтгөх явдал нэн чухал шаардлага болон тавигдсан юм. Шинэтгэл, нээлттэй байх бодлого нь хэдэн арван жил баримтлах урт удаан хугацааны стратегийн чиг шугам мөнийг хятадын албан ёсны баримт бичгүүдэд нотолсоор байна.

БНХАУ-ын гадаад, дотоод бодлого харилцан шүтэлцээтэй болсноор тус орны нийгэм, эдийн засагт өөрчлөн байгуулалт амжилттай хэрэгжихийн нэг нөхцөл бүрэлдсэн байна. Гадаадад нээлттэй байх нь БНХАУ-ын бие даасан, энх тайванч гадаад бодлогын чухал бүрэлдэхүүн хэсэг юм. 1986 оны 3 дугаар сарын 25-нд БХАТХ-ын VI дахь удаагийн IV чуулганаар баталсан «БНХАУ-ын бие даасан, хараат бус энх тайванч гадаад бодлогын гол чиглэл, үндсэн зарчим» хэмээх 10 зүйлт баримт бичигт «хятад улс гадаадад нээлттэй байх бодлогыг урт хугацаанд тууштай баримталж, тэгш эрхтэй, харилцан ашигтай байх зарчмын үндсэн дээр олон оронтой эдийн засаг, худалдаа, шинжлэх ухаан, техникийн солилцоо, хамтын ажиллагаагаа тасралтгүй өргөтгөн хөгжүүлнэ. Хятадын нээлттэй бодлого бүх дэлхийд, капиталист оронд ч, мөн социалист оронд ч, хөгжингүй оронд ч, хөгжиж буй оронд ч нэгэн адил нээлттэй байна» гэж заасан юм¹.

Хятад улс энэ бодлогоо хэрэгжүүлэх үүднээс 1979 оноос хойш олон чухал арга хэмжээ авлаа. Эдийн засгийн онцгой район, эдийн засгийн нээлттэй бүс байгуулах, далайн эрэг орчмын хотуудыг нээлттэй болгох замаар гадаад орнуудтай техник, эдийн засгийн талаар хамтран ажиллаж, гадаадын хөрөнгө, шинэ техник, технологийг оруулж, өндөр мэргэжлийн боловсон хүчин, шинжлэх ухаан, техникийн сүүлийн үеийн мэдээллийг өргөн ашиглах болов.

1982 онд баталсан Хятадын шинэ Үндсэн хуулиар тус оронд гадаадын хөрөнгө оруулалтыг зөвшөөрчээ. Шинэтгэл, нээлттэй бодлогыг хэрэгжүүлэх үүднээс гадаадын хөрөнгө оруулах, гадаадтай хамтран үйлдвэр, аж ахуйн газар байгуулах тухай 100 гаруй хууль гаргаж, энэ асуудлаар олон оронтой гэрээ, хэлэлцээ байгуулав.

Тус орны экспорт, импортын хэмжээ ихээхэн өсч, гадаад худалдаа өргөжив. Улсын өмчийг гол болгосон олон хэвшилт эдийн засаг хэлбэршин тогтлоо.

БНХАУ нээлттэй бодлогоо хэрэгжүүлэх явцад гадаад эдийн засгийн хамтын ажллагаагаа өрөгжүүлэх идэвхтэй эрэл хайгуул хийж мэдэгдэхүйц үр дүнд хүрсэн нь бидний сонирхлыг татаж байна. Ийм эрэл хайгуулын нэг нь хятадад олон улсын жуулчлалыг эрчимтэй хөгжүүлж байгаа явдал юм.

1978 онд 1.8 сая гадаадын жуулчин хятадад ирж, тус орон жуулчдадаас 26 сая америк долларын орлого олж байсан бол 1988 онд

жуулчдын тоо 31,7 сая, орлогын хэмжээ 2,25 млрд. ам. долларт хүрчээ.² Энэ нь 10 жилд жуулчдын тоо 17,6 дахин, ашгийн хэмжээ 8,6 дахин өссөн гэсэн үг юм. 1989 онд хятадад 24,5 сая хүн жуулчлалаар ирж, 1 млрд. 810 мянган ам. долларын орлого олсон нь 1988 оныхоос тус бүр 22,7 ба 19,6%³ буурсан боловч жуулчлал нь гадаадад нээлттэй бодлогын чухал чиглэл хэвээр байна.

1988—1989 онд Хятадад 163,5 сая жуулчин ирж, үүнээс 12 млрд. 640 сая долларын орлого олсон тооцоо гарч байна.

Хэдийгээр Хятадад 170 орчим улс, бүс нутгаас жуулчид ирдэг боловч дийлэнх олонх буюу 93 гаруй хувь нь Гонконг, Макао, Тайван болон бусад орны хятадын эх орон нэгтэнгүүд юм. Хятадын хэвлэлд мэдээлснээр тус оронд оруулж буй гадаадын хөрөнгө оруулсан үйлдвэрийн 80%, шууд хөрөнгө оруулалтын 70 гаруй хувийг хилийн чанад дахь хятад иргэд оруулдаг аж⁴.

Тэдний эх орноо гэх сэтгэлийг Хятадын эдийн засгийг хөгжүүлэхэд чухал хүчин зүйл болгон ашиглаж байна. 5 тивийн 100 гаруй улс орон, бүс нутагт суугаа 30 сая гаруй цагаач хятадууд, хятад гаралтай гадаадын иргэд нь Хятад дахь гадаадын хөрөнгө оруулалтын 60 хувийг оруулж байгаагаар тэдний хувь нэмрийг үнэлж болох юм. Хуацяо, хуажэнь нар аж үйлдвэр, хөдөө аж ахуй, тээвэр, ахуйн үйлчилгээний бүхий л салбарт хөрөнгө оруулаад зогсохгүй багагүй хэмжээний буцалтгүй тусламжийг эх орондоо өгч байна. Хэвлэлийн мэдээгээр 1978—1988 онд тэд 800 сая ам. долларыг бэлэглэсэн байна. Жил бүр 200 сая хүртэл долларыг цагаач хятадууд БНХАУ-д суугаа төрөл төрөгсөддөө гуйвуулдаг байна. Ганц жишээ хэлэхэд Гонконгийн үйлдвэрийн эзэн Хо Индун Азийн XI тоглолтод зориулж 1 сая гонконг долларыг эх орондоо бэлэглэсэн бөгөөд тэрээр урьд нь зам тавих, зочид буудал, эмнэлэг барих, боловсрол, биеийн тамирыг хөгжүүлэхэд 80 сая ам. доллар өгч байжээ.⁵

БНХАУ бол гадаадад суугаа бүх хятад цагаач, хятад гаралтай хүмүүсийн эх орон мөн гэж үздэг энэ бодлого тус орны эдийн засгийн шинэтгэл, нээлттэй бодлогын салшгүй нэг хэсэг болж байна.

Хятадын гадаад эдийн засгийн үйл ажиллагааны бас нэг хөндүүштэй асуудал бол «хөдөлмөрөөр туслах» асуудал юм. Ингэж ажиллах хүчнээ гадаадад гаргаснаар ажилгүй хүмүүс ажилттай болж, нарийн мэргэжил эзэмшиж, боловсролоо дээшлүүлэн, гадаад орны амьдралтай танилцан, юм үзэж, нүд тайлах өргөн боломж олгож байгаа юм. Энэ нь БНХАУ олон улсын хөдөлмөрийн зах зээл дээр гарахад чухал алхам болж байна.

Хятадаас гадаад оронд «хөдөлмөрөөр туслах» явдал жилээс жилд өссөөр байна. 1976—1978 онд энэ асуудлаар гадаадтай долоохон хэлэлцээр хийсэн бол 1988 онд 1650 хэлэлцээр байгуулжээ.⁵

Сүүлийн жилүүдэд манай орон хятад ажилчдыг мөн гэрээгээр авч эхэллээ. 80-аад оны эцэст, ажиллах хүчээ гадаадад гаргах энэ үйл ажиллагаа тус орны олон улс оронтой эдийн засгийн харилцаа тогтоон өргөжүүлэх нэг суваг, валютын нөөцийг арвижуулах чухал эх булаг болжээ.

Гадаадын жуулчлалыг хөгжүүлж, хятад цагаач, хятад гаралтай иргэдээ эдийн засгийнхаа хөгжилд татан оролцуулж, ажиллах хүчнээ таваар болгон ашиглаж байгаа эдгээр ажиллагаа нь тус орны валютын орлогын 80% -ийг оруулдаг экспортын хэмжээг нэмэгдүүлэхэд үлэмжхэн үүрэг гүйцэтгэж байна.

Эдийн засгийн нээлттэй бодлого явуулж буй манай орны хувьд хөрш зэргэлдээ БНХАУ-ын нээлттэй бодлогыг бодитой үнэлж, задлан

шинжлэх явдал зайлшгүй чухал, хойш тавьж боломгүй асуудал юм. Үнэнийг хэлэхэд ийм судалгаа бидэнд үгүйлэгдэж байна.

БНХАУ-ын шинэтгэл, нээлттэй бодлого явуулсан 12 жилийн практикийг эргэн үзвэл бусад орны хөгжлийн явцад тохиолдсон, тохиолдож болох өвөрмөц онцлог, нийтлэг сургамж, туршлага болохуйц зүйл цөөнгүй байна.

Юуны өмнө гадаадад нээлттэй байх бодлого нь эдийн засгийн шинэтгэлтэйгээ нягт уялдаатай, өөрөөр хэлбэл нийгэм, эдийн засгийн ашиг сонирхолд зохицсон харилцан шүтэлцсэн байлаа. Нөгөө талаар эдийн засгийн шинэтгэлд гадаад хүчин зүйлийг идэвхтэй ашиглахад чиглэсэн тус орны гадаад бодлого нь энх тайван орчин, сайн хөршийн найрсаг харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэхэд бодитойгоор сайн нөлөө үзүүллээ. Дотооддоо эдийн засгийн шинэтгэлийг эрчимтэй хийхгүйгээр нээлттэй бодлого явуулах нь үр дүнд хүрдэггүйг БНХАУ-ын шинэтгэлийн өмнөх жилүүдийн туршлага харуулсан юм.

Сүүлийн жилүүдэд, ялангуяа 80-аад оны дунд үеэс хойш БНХАУ хөрш зэргэлдээ орнуудтай харилцаагаа сэргээн, сайжруулж, худалдаа, эдийн засгийн хэлхээ холбоогоо өргөжүүлсэн явдал «нээлттэй бодлогын» чухал үр дүн боллоо. Олон улсын тааламжтай нөхцөл бүрэлдүүлж чадвал улс, орны эдийн засагт чухал нөлөөтэй БНХАУ чухам ийм замаар амжилтанд хүрлээ.

БНХАУ-ын шинэтгэл, нээлттэй бодлогын бас нэг чухал сургамж бол тус орон тодорхой нөхцөл байдалд, практик ажлын явцад үндэсний гагцхүү хятадын онцлогийг сайтар харгалзан үзсэн юм. Бусдын туршлагыг хуулбарлан дууриалгүй, «Хятадын онцлогтой социализм» байгуулах хэрэгтэй гэсэн дүгнэлтийг ХКН-ын XIII их хурал хийсэн юм.

Улс орны дотоод амьдрал, нийгмийн тогтвортой байдал, гадаад бодлого, олон улсын нэр хүнд нь гадаадын хөрөнгө оруулах, хамтарсан үйлдвэр, аж ахуйн газар байгуулах, засгийн газрын болон олон улсын байгууллагын шугамаар зээл авахад харгалзах хүчин зүйл болдогийг БНХАУ-ын шинэтгэлийн жилүүд харууллаа.

Нээлттэй бодлогын жилүүдэд нийгмийн ухамсарт гарсан зөрчил хурцдаж байлаа. Нийгмийн элдэв сөрөг үзэгдэл, дамын наймаа, хээл хахуулийн хэрэг, албан тушаалаа хортойгоор ашиглах г. м. эдийн засгийн гэмт хэрэгтэй шийдвэртэй тэмцэх явдал улс орны хувь заяаны асуудалтай холбогдон гарч байлаа.

Үзэл суртлын тогтсон загвар, дассан хэвшлээс ангижрах үйл явцад шинэ шинэ бэрхшээл гарах, аж үйлдвэрт түлш, түүхий эд дутагдах, мөнгөний ханш буурах, юмны үнэ өсөх г. м. нийгэм, эдийн засгийн асуудлууд тулгарах, эдийн засгийн шинэтгэлээс ардчилах үйл явц хоцорвол нийгмийн хямралт байдал үүсэх зэрэг эгзэгтэй нөхцөлд улс орны удирдлагаас улс төрийн тэвчээр, зориг, туршлага шаардагдгийг амьдрал харуулж байна.

Гадаадын хөрөнгө оруулалт, шинэ техник, технологийг ашиглахдаа нэгэнт байгаа материаллаг баазаа түшиглэх, уламжлалт бүтээгдэхүүнийхээ чанарыг дээшлүүлэх замаар экспортыг хөгжүүлэх, дэлхийн зах зээлд гарах арга замыг идэвхтэй эрэлхийлэх нь чухлыг хятадын эдийн засгийн онцгой район, нээлттэй хотуудын туршлага харууллаа. Хятадын нээлттэй эдийн засгийн бүсийн туршлагыг нарийвчлан задлан шинжлэх, газар дээр нь үзэж танилцах асуудал чухал байна.

Гадаадын хөрөнгө оруулсан буюу нээлттэй болгосон тухайн орон нутагт үйлдвэрлэлийн дэд бүтцийг тууштай хөгжүүлэх, тэндэх нийгмийн асуудлыг зохистой шийдвэрлэх, юуны өмнө зам тээврийн бэрхшээлийг арилгах, олон улсын шуудан, телефон, телеграфийн харилцааг

бий болгох нь ихээхэн чухал ач холбогдолтой, анхаарлын төвд байнга байх асуудал юм.

Гадаад эдийн засгийн харилцааны эрх зүйн үндсийг баталгаатай болгох, энэ талын хууль тогтоомжуудыг шинээр нэн даруй гаргах, боловсронгуй болгохоос хамтын ажиллагааны байдал, хэтийн төлөв ихээхэн шалтгаалдгийг БНХАУ-ын туршлага нотолж байна.

Орчин үеийн шинэ техник, технологийг хэрэглэхэд боловсон хүчний мэдлэг, боловсрол, ажлын арга туршлага дутагдах бэрхшээлийг даван туулахын тулд техник, мэргэжлийн өндөр түвшинтэй ажиллах хүчийг дотоод, гадаадаа өргөнөөр бэлтгэсэн БНХАУ-ын туршлага ч сонирхолтой юм.

Шинэтгэл, нээлттэй бодлогын үндсэн дээр БНХАУ-д шинэчлэл хийх, дэлхийн тэргүүний орны нэг болгохоор 70-аад оны дунд үеэр дэвшүүлсэн хятадын стратеги бол ямар нэгэн тодорхой программ биш, илүү өргөн ойлголт юм. Бид өнгөрсөнд цөөнгүй программ дэвшүүлж байсан боловч ихэнхдээ үр дүн нь санаснаар болж байсангүй. Хөгжлийн урт удаан хугацааны зөв стратеги боловсруулахад Хятадын туршлага маргаангүй үнэтэй байх болно.

1. «Чжунго вайцзяо гайань» —1987» (Хятадын гадаад бодлогын товч лавлах -1987) Бээжин, 1987, 17-р тал
2. Чжунго цзинцзи няньцзянь — 1988 XI — 97-р тал
3. Чжунхуа жэньминь гункэто говүюань гунбао 1990.
4. Жэньминь жибао 1989. 5. 20.
5. Е. П. Бажанов. Китай и внешний мир. М, 1990, с. 8